



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 9/50.

Мандалговь

└ “Сургуулийн барилгын дээврийн засвар”
/Дундговь, Сайнцагаан сум, Эрдмийн далай цогцолбор/-ын
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний
хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сургуулийн барилгын дээврийн засвар /Дундговь, Сайнцагаан сум, Эрдмийн далай цогцолбор/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: А.Нарантуяа (Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Ц.Бямбацогт (Иргэний төлөөлөл)

Х.Анхбаяр (Хот тохижуулах газрын дарга)

Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын ХАА хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (А.Нарантуяа)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060137